

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалагат, Дорноговь аймгийн Төрийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн”



**ҮДИЙН ЦАЙНД ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ДҮГНЭЛТГҮЙ БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЖ БАЙНА.**

2018 он

АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Дорноговь аймгийн Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежерын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа</p> <p>Аудитор П.Энхбаяр Шинжээч У.Баттуяа</p> <p>2018 оны 10 дугаар сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр</p>	<p>Товчилсон үгийн тайлбар -----3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.-----4-5</p> <p>Бүлэг 1. Хөтөлбөрийн санхүүжилтийг илүү төлөвлөснөөс зарим сургуулиуд зориулалт бусаар зарцуулсан байна.</p> <p>1.1 Хүүхдийн тоог үндэслэн санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна.-----6-8</p> <p>1.2 Санхүүжилтийг төлөвлөсний дагуу олгож байгаа ч зарим сургуулиуд зориулалтын дагуу зарцуулаагүй байна-----8-9</p> <p>Бүлэг 2. Үдийн цайгаар хүүхдийн нас биед тохирсон бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлж чадахгүй байна.</p> <p>2.1 Бэлтгэн нийлүүлэгчийг сонгох ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй байна.-----9-11</p> <p>2.2 Хүүхдийн нас биед тохирсон амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүн нийлүүлэгдэж чадахгүй байна.—11-12</p> <p>Бүлэг 3. Шинжилгээний дүгнэлтгүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байна.</p> <p>3.1 Талууд журмын заалтыг мөрдөөгүйгээс бүтээгдэхүүний чанар, илчлэг норм нь шалгуурыг хангахгүй байна.-----12-14</p> <p>3.2 Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсан, шинжилгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн үдийн цайнд олгож байна. ---14-16</p> <p>Бүлэг 4. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй байна.</p> <p>4.1 Холбогдох журмын заалтыг мөрдөж ажиллаагүйгээс өдөр тутмын хяналт хангалтгүй байна.-----16-19</p> <p>4.2 Орон нутагт мэргэжлийн байгууллагууд хяналтаа хамтран хэрэгжүүлсэн байна.-----19-21</p> <p>Дүгнэлт-----21</p> <p>Зөвлөмж-----22</p> <p>Холбогдох байгууллагын санал-----23-24</p>
---	---

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
МУЗГ	Монгол улсын засгийн газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БСШУ	Боловсрол соёл шинжлэх ухаан
БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМ	Эрүүл мэнд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕБ	Ерөнхий боловсрол
ТББ	Тендерийн баримт бичиг
СС	Сангийн сайд
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨӨЗ	Тендер оролцогчдод өгөх зааварчилгаа
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААН	Аж ахуйн нэгж
ЭМГ	Эрүүл мэндийн газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгийн газар
ЗД	Засаг дарга
НХБ	Нийгмийн хөгжлийн бодлого

АУДИТЫН ТУХАЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/106 дугаар тушаалаар батлагдсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт: Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг аймгийн ИТХ болон холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэлээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд асуудлыг авч үзсэн. Үүнд:

- Үдийн цай хөтөлбөрт олгох хөрөнгийг оновчтой төлөвлөсөн эсэх
- Үдийн цайны хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн байдал
- Хүнсний бүтээгдэхүүний чанар, илчлэг, орц нь стандартад нийцэж, эрүүл ахуй аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт үр нөлөөтэй байгаа эсэх

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав.

- МУ-ын ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоол
- Төсвийн тухай хууль
- БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаал.
- ЭМС-ын 2014 оны 113 тушаал
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Иргэний хууль,
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам",
- БСШУС, СС-ын хамтарсан 2009 оны 560,276 тушаалаар батлагдсан хөтөлбөрийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журам
- Төрийн аудитын тухай хууль
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал
- Иргэний хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Бусад холбогдох эрх зүйн актууд.

Хамарсан хүрээ: Аудитаар 2017-2018 он, 2018-2019 оны хичээлийн жилийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, БСУГ, Айраг, Замын-Үүд, Хөвсгөл, Сайншанд, Даланжаргалан, Мандах, Сайхандулаан сумдын ЕБ-ын сургуулийг хамруулан, бэлтгэн нийлүүлэгч сонгон шалгаруулсан ТББ, дүгнэлт, тэмдэглэл, гэрээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитад Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим АДБОУС (300), Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг мөрдөж дараах горимыг гүйцэтгэлээ.

- Аймгийн хэмжээний нийт 22 сургуулийн 12 сургуульд Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг шалгав.
- Сургуулиудаас ирүүлсэн тайлан мэдээг судалж үнэлэлт, дүгнэлт хийсэн,
- Үдийн цай хөтөлбөрт хамрагдах сурагчдын төлөвлөсөн тоог ирцийн бүртгэлтэй харьцуулах, санхүүжилтийн тооцоолол, хэмнэлт хэтрэлтийн талаар дүн шинжилгээ хийх, нийлүүлэлтийн тооцоог холбогдох баримттай тулган шалгасан,
- Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг судалж дүн шинжилгээ хийсэн,
- Сургуулийн захирал, эцэг эхийн хяналтын зөвлөлийн гишүүдийн төлөөлөл, БСУГ-ын бага боловсрол болон төсөв хариуцсан мэргэжилтэн, МХГ-ын улсын байцаагч, сумын ХАА хариуцсан мэргэжилтэн, сургуулийн эмч, нягтлан бодогч, тогооч болон бусад холбогдох хүмүүстэй онилсон бүлгийн хэлэлцүүлэг болон ярилцлага хийсэн;
- Аудитын явцад Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар сурагчид, багш нарыг хамруулан нийт 373 хүнээс санал асуулга авч нэгтгэн, шинжилгээ хийж харьцуулалт хийв. Санал асуулгад 11 сургуулийн 22 ангийн 351 сурагч, бага ангийн 22 багш хамрагдсан.
- Бэлтгэн нийлүүлэгч сонгох ажиллагаа нь хууль дүрэм журамд нийцсэн эсэхийг аудитад хамрагдсан сургууль тус бүрээр хянасан.
- Нөхцөл байдлын шинжилгээ, тулган баталгаажуулалт, харьцуулалт зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын хугацаа: Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 24-нд эхлүүлж, аудитын талбарын ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 27-оос 10 дугаар сарын 26-ны өдрүүдэд гүйцэтгэж, 2018 оны 10 дугаар сарын 29-нөөс эхлэн тайлангийн төсөл боловсруулан, удирдлагын санал авч, шалгагдагч байгууллагад 2018 оны 11 дүгээр сарын 05-нд хүргүүлэн санал авч, 11 дүгээр сарын 09-нд эцэслэн боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорноговь аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа хэрэгжүүлж, аудитор П.Энхбаяр, гэрээт ажилтан У.Баттуяа нар гүйцэтгэв.

Бүлэг 1.**Хөтөлбөрийн санхүүжилтийг илүү төлөвлөснөөс зарим сургуулиуд зориулалт бусаар зарцуулсан байна.****Ерөнхий зүйл**

1. Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай УИХ-ын 2006 оны 47 дугаар тогтоол, уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2006 оны 66 дугаар тогтоол, Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай МУЗГ-ын 2006 оны 194, 2012 оны 106 дугаар тогтоолуудыг үндэслэн Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

2. БСШУС, ЭМС-ын 2006 оны 379/341 дугаар хамтарсан тушаалаар ЕБС-ийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам батлагдаж, 2006 онд I-II анги, 2007 онд I-IV ангийн суралцагчид өдөрт 300 төгрөгт багтаан, Засгийн газрын 2008 оны 45 тоот тогтоолоор хөтөлбөрт хамрагдах хүрээ болон үнэ өртгийг өөрчилж I-V ангийн суралцагчид 400 төгрөгөөр, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор 2013 оны эхнээс нэг сурагч өдөрт 600 төгрөгийн үдийн цайны зардал хэрэглэхээр тогтоожээ.

3. Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан ЗГ-ын тогтоол болон холбогдох сайдын гаргасан журмуудад хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэврийн талаар орон нутгийн засаг захиргааны хүлээх үүргийг тодорхойлоогүй, хөтөлбөрийн зардлын төлөвлөлт, тайлагналын асуудлын талаар нарийвчлан тусгагдаагүй байна.

1.1 Санхүүжилтийг хүүхдийн тоонд үндэслэн бодитой төлөвлөөгүй байна.**Үдийн цайнд хамрагдах хүүхдийн тоог бодитой тооцоолоогүй байна.**

1.1.1 Үдийн цай хөтөлбөрт 2015-2016 оны хичээлийн жилд нийт 22 сургуулийн 6195 сурагч, 2016-2017 онд 6567, 2017-2018 онд 6968 сурагч хамрагдсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд 7279 сурагч хамрагдаж байгаа нь нийт суралцагчдын 56.0 хувийг эзэлж байна.



1.1.2 Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж буй ЕБС-дад Төсвийн тухай хуульд заасны дагуу 2016-2018 оны төсвийн төслийг аймгийн БСУГ, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст жил бүр ирүүлсэн байна.

1.1.3 Сургуулиуд төсвийн төсөл боловсруулахдаа үдийн цайнд хамрагдах хүүхдийн тоог 2016 онд 104449 хүүхэд өдрөөр, 2017 онд 100462 хүүхэд өдрөөр, 2018 онд

51735 хүүхэд өдрөөр илүү тооцож төслөө хүргүүлсэн байна. Тоон мэдээллийг хүснэгтээр харуулав.

Хүүхдийн тоо 2016-2018 /хүүхэд өдөр/

2016 он			2017 он			2018 он		
Төсвийн төслөөр	БСУГ-ын төлөвлөж буй	Зөрүү	Төсвийн төслөөр	БСУГ-ын төлөвлөж буй	Зөрүү	Төсвийн төслөөр	БСУГ-ын төлөвлөж буй	Зөрүү
1070720	966270	104450	1135855	1035393	100462	1195095	1143360	51735

1.1.4 Хүүхдийн тоо илүү төлөвлөгдсөн байгааг аймгийн БСУГ-ын төсвийн мэргэжилтнээс тодруулахад “хичээлийн жил, төсвийн жил тохирдоггүйтэй холбоотойгоор үдийн цайны жилийн зардлыг төлөвлөхдөө тухайн оны 1-6 дугаар сарын хүүхдийн тоог урьд оны 9 дүгээр сард сургуулиудын гаргасан статистик тайлан мэдээгээр, харин 9-12 дугаар сарын хүүхдийн тоог суралцах хүүхдийн тооны прогноз хэлбэрээр тооцож дунджийг гарган хүүхдийн тоог төлөвлөдөг. Хүүхдийн тооны прогнозыг 1, 10 дугаар ангиас бусад ангийг дэвшүүлэн тооцдог, харин 1 дүгээр ангийн хүүхдийн тоог 6 настай бүх хүүхдийг 100 хувь сургуульд хамруулахаар тооцож төлөвлөсөн, мөн 2017-2018 оны хичээлийн жилд шинээр ашиглалтад орох сургуулийн тоог харгалзсан” гэж тайлбар өгсөн.

Санхүүжилтийг хүүхдийн тоонд үндэслэн төлөвлөөгүй байна.

1.1.6 Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс аймгийн БСУГ-аас ирүүлсэн хүүхдийн тоонд үндэслэн хөтөлбөрийн санхүүжилтийг төлөвлөсөн байна. Батлагдсан төлөвлөгөөг БСУГ-ын 2017, 2018 оны статистик мэдээ, хүүхдийн тооны прогнозоор тооцож үзэхэд 2017 онд 1034647 хүүхэд өдөр буюу 620.7 сая төгрөг батлагдахаар тооцоо гарсан боловч тухайн онд 682.9 төгрөгөөр батлагдсан байгаа нь хүүхдийн тоонд үндэслэн төлөвлөөгүй байна. Үдийн цай хөтөлбөрийн 2017 оны хөрөнгийн төлөвлөлтийг сургууль тус бүрээр хүснэгтээр харуулав /сая төгрөгөөр/.

№	Сургуулийн нэр	Нийт хүүхэд өдөр	Норм	Жилд батлагдвал зохих	2017 онд батлагдсан	Зөрүү	2017 ИТХ Тод-1	2017 ИТХ Тод-2
1	Айраг сургууль	52,314	600	31.4	32.5	1.1	31.4	31.4
2	Алтанширээ сургууль	12,496	600	7.5	7.5	0.0	7.5	8.2
3	Даланжаргалан сургууль	34,474	600	20.7	22.7	2.0	20.7	22.2
4	Дэлгэрэх сургууль	27,074	600	16.2	16.2	0.0	16.2	16.2
5	Замын-Үүд 1-р сургууль	116,448	600	69.9	55.5	-14.4	64.5	69.9
6	Замын-Үүд 2-р сургууль	92,542	600	55.5	55.5	0.0	55.5	55.5
7	Замын-Үүд 3-р сургууль	62,832	600	37.7	55.5	17.8	30.8	37.7
8	Замын-Үүд хувийн сургууль	17,302	600	10.4	10.4	0.0	10.4	10.4
9	Иххэт сургууль	28,311	600	17.0	18.0	1.0	18.0	17.0
10	Мандах сургууль	20,185	600	12.1	12.1	0.0	12.1	10.9
11	Өргөн сургууль	22,428	600	13.5	13.5	0.0	13.5	13.5
12	Сайншанд 1-р сургууль	123,226	600	73.9	73.4	-0.5	71.9	73.9
13	Сайншанд 2-р сургууль	134,182	600	80.5	81.9	1.4	81.9	80.5
14	Сайншанд 3-р сургууль	65,842	600	39.5	85.2	45.7	39.5	39.5
15	Сайншанд 4-р сургууль	31,215	600	18.7	16.9	-1.8	16.9	18.7
16	Сайншанд 5-р сургууль	69,589	600	41.7	45.8	4.1	45.8	41.8
17	Сайхандулаан сургууль	12,496	600	7.5	7.5	0.0	7.5	7.5
18	Улаанбадрах сургууль	18,295	600	11.0	16.8	5.8	14.8	11.0
19	Хатанбулаг сургууль	36,365	600	21.8	21.8	0.0	21.8	21.8
20	Хөвсгөл сургууль	24,11	600	14.7	14.7	0.0	14.7	14.2
21	Эрдэнэ сургууль	32,521	600	19.5	19.5	0.0	19.5	19.5
	Нийт дүн	1034,647		620.7	682.9	61.7	614.9	621.2

1.1.7 “Хөгжлийн төлөө хамтдаа” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1-д тусгагдсан тэргүүлэх зорилтын хүрээнд Замын-Үүд суманд 960 хүүхдийн сургуулийн барилга шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөн тус сумын 3-р сургуулийн төсвийг 17.8 сая төгрөгөөр, Сайншанд сумын 4-р багт 320 хүүхдийн бага сургууль барихаар төлөвлөн тус сумын 3-р сургуулийн төсвийг 45.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, шинээр ашиглалтад орох сургуульд шилжилт хөдөлгөөн хийгдэхээр тооцон Замын-Үүд сумын 1-р сургуулийн төсвийг 14.4 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

1.1.8 Тайлант онд төлөвлөсөн барилга байгууламжууд хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан хугацаандаа ашиглалтад ороогүй, 6 настнууд сургуульд бүрэн хамрагдаагүй, сурагчдын шилжилт хөдөлгөөн зэргээс шалтгаалан 2017 онд батлагдсан хөрөнгийг аймгийн ИТХ-аар 2 удаа тодотгон зохицуулалт хийсэн байна.

1.1.9 2018 оны төсвийн төслийг БСУГ-аас ирүүлсэн тоотой уялдуулан төлөвлөсөн байна. Тухайн онд үдийн цай хөтөлбөрт 1143360 хүүхэд өдөр буюу 669.8 сая төгрөгөөр тооцон баталсан байна.

1.2 Санхүүжилтийг төлөвлөсний дагуу олгож байгаа ч зарим сургуулиуд зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Хөтөлбөрийн санхүүжилтийг төлөвлөсний дагуу олгосон байна.

1.2.1 Тендерт шалгарч гэрээ байгуулсан компаниудад үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо сургуулиуд тухайн сард хичээлд ирсэн хүүхдийн тоогоор тооцож хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авсан баримт материалд үндэслэн сар тутамд шилжүүлсэн байна.

1.2.2 Сургуулиуд өдөрт 600 төгрөгөөр тооцож үдийн цайны цэсийг 7-14 хоногоор зохиож батлуулан мөрдөж ажиллажээ. Өөрөөр хэлбэл нэг хүүхдэд өдөрт 600 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгож, тухайн сарын гүйцэтгэлийг үндэслэн нийлүүлэгч компанид санхүүжилтийг олгож байна.

1.2.3 2015-2016 оны хичээлийн жилд нийт 21 ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрт I-V ангийн 6195 сурагч хамруулан үдийн цайны зардалд 589.2 сая төгрөг, 2016-2017 оны хичээлийн жилд 6567 сурагч хамруулан 565.4 сая төгрөг, 2017-2018 оны хичээлийн жилд 6968 хүүхэд хамруулан 610.7 сая төгрөг, 2018-2019 оны хичээлийн жилд 7279 хүүхэд хамруулан эхний хагас жилийн байдлаар 313.8 сая төгрөг зарцуулсан байна. Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулав.

/сая төгрөгөөр/

2018 он		2017 он		2016 он	
Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
686.0	313.8	621.2	610.7	579.8	565.4

Үдийн цайны зардлаас 2.4 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

1.2.4 2017-2018 оны хичээлийн жилийн хүүхдийн ирцийн дүнд 62.1 сая төгрөг хэмнэгдсэнийг цалингийн зардалд шилжүүлэн аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор тодотгосон байна.

1.2.5 Үдийн цай хөтөлбөрийн 2017 оны зардлын төсвөөс сургуулийн дотуур байрны хоолны зардалд болон бусад сургуулийн бэлтгэн нийлүүлэгчид зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан байна. Үүнд:

- **Сайншанд 1-р сургууль:** Дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэгч Мандах баян ХХК-д 190.5 мянган төгрөг, Говийн шинэ өглөө ХХК-д 144.3 мянган төгрөг, Таван хааны өргөө ХХК-д 918.0 мянган төгрөг нийт 1252.8 мянган төгрөгийг, иргэн М.Содномнамжилмаад 287.2 мянган төгрөгийг жимсний үнэ гэж үдийн цай хөтөлбөрийн зардлаас тус тус шилжүүлсэн.
- **Сайншанд 3-р сургууль:** Суман зурхай ХХК-д махны үнэ 386.2 мянган төгрөг шилжүүлсэн.
- **Замын-Үүд 2-р сургууль:** Үдийн цай хөтөлбөрийн 526.2 мянган төгрөгийг 3-р сургуулийн бэлтгэн нийлүүлэгч Даян сайн сайхан ХХК-д шилжүүлсэн.

1.2.6 Аудитад хамрагдсан 12 байгууллагын дүнгээр 2017 онд нийт 8.9 сая төгрөгийн хэмнэлт гарсныг Төрийн сангийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Бүлэг.2

Үдийн цайгаар хүүхдийн нас биед тохирсон бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлж чадахгүй байна.

2.1 Бэлтгэн нийлүүлэгчийг сонгох ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Үнэлгээний хороо бэлтгэн нийлүүлэгчийг шалгаруулахдаа журмын заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

2.1.1 Сайншанд сумын ЕБС-дад үдийн цай нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн ОНӨГ 2017 оноос эхлэн зохион байгуулжээ. Аймгийн Засаг даргын 2018 оны А/509 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулан тендерийн бичиг баримтыг боловсруулжээ. Тендерийг 9 багц болгон зарлан, урилгыг ЗГ-ын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна.

2.1.2 Замын-Үүд сумын ЕБС-дад үдийн цайны бэлтгэн нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг сумын ЗАА зохион байгуулжээ. Сумын Засаг даргын 2018 оны А/156 тоот захирамжаар томилогдсон үнэлгээний хороо тендерийн бичиг баримтыг боловсруулан, нээлттэй тендер шалгаруулалтаар бэлтгэн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулсан байна. Үнэлгээний хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд БСУГ-аас төлөөлөл оролцуулдаггүй байна.

2.1.3 Дээрх үнэлгээний хороод гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалаар батлагдсан журмын гэрээт гүйцэтгэгчийг сонгоход баримтлах шалгуурын 5.2-д “Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх”, ТӨӨЗ 12.1-д Нэгж бүтээгдэхүүний үндсэн шимт бодис тооцсон мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт ирүүлэх гэж заасныг харгалзаагүй байна. Тухайлбал

- Сайншанд сумын 1, 5 дугаар сургуульд махан болон цагаан хоол нийлүүлэхээр шалгарсан **Алтан чуу ХХК**-ний үдийн цайнд нийлүүлэх бүх нэр төрлийн хоол лабораторийн шинжилгээнд хамрагдаагүй, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ тооцуулаагүй.
- Сайншанд сумын 3-р сургуульд махан болон цагаан хоол нийлүүлэхээр шалгарсан **Алтан түүчээгийн говь ХХК**-ний үдийн цайнд нийлүүлэх 10 нэр төрлийн хоолны 6 төрөл, гурилан бүтээгдэхүүн нийлүүлэхээр шалгарсан Мөнгөн сүндэр ХХК-ний 7 нэр төрлөөс 3 төрөл нь тус тус лабораторийн шинжилгээнд хамрагдаагүй байна.
- Замын-Үүд сумын 3-р сургуульд үдийн цай нийлүүлэхээр шалгарсан Даянсайн сайхан ХХК-ний нийлүүлэх 13 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 10 нь лабораторийн шинжилгээнд хамрагдаагүй,
- Замын-Үүд сумын 1-р сургуульд бүтээгдэхүүн нийлүүлэхээр шалгарсан Борбилэг ХХК-ний 20 нэр төрлийн бүтээгдэхүүний 18 нь лабораторийн шинжилгээнд хамрагдаагүй.

2.1.4 ТББ-ын ажлын тоо хэмжээнд долоо хоногт нийлүүлэх бүтээгдэхүүний давтамжийг 2 удаа байхаар заасан. Гэтэл Сайншанд сумын 3-р сургууль цэс боловсруулахдаа Мөнгөн сүндэр ХХК-ийн гурилан бүтээгдэхүүнийг долоо хоногт 1 удаа авахаар боловсруулж мах, цагаан хоол нийлүүлэх Алтан түүчээгийн говь ХХК-аас гурилан бүтээгдэхүүн буюу бүхэл үрийн талхыг 200 төгрөгөөр авахаар зохиосон байна.

2.1.5 ОНӨГ аймгийн төвийн сургуулиудын 2017 оны үдийн цай бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан зарим баримтыг ирүүлээгүйгээс Сайншанд сумын 1.2.5 дугаар сургуулийн махан болон цагаан хоол нийлүүлэгчийг хэрхэн сонгон шалгаруулсан байдлыг тодорхойлох боломжгүй байна.

2.1.6 Бэлтгэн нийлүүлэгчийг сонгохдоо журмын шалгуурыг мөрдөөгүйгээс үдийн цайнд шинжилгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн нийлүүлсээр байна.

Ихэнх сумдын бэлтгэн нийлүүлэгчийг сонгох ажиллагаа хуульд журамд нийцэхгүй байна.

2.1.7 Дорноговь аймагт үдийн цай хэрэгжүүлдэг 22 сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд I-V ангид 7279 хүүхэд суралцаж байна. Эдгээр сургуулиас үдийн цайнд хамгийн багадаа нэг ээлжинд 84 хүүхэд /Сайхандулаан/, хамгийн их нь 824 хүүхэд /Сайншанд 2-р сургууль/ хамрагдаж байна.

2.1.8 Үдийн цай хөтөлбөрийн бэлтгэн нийлүүлэгчийг сонгохдоо хууль¹, журмын² заалтыг мөрдөж ажиллаагүйгээс ихэнх сумдад бүтээгдэхүүн нийлүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнгүйгээр дараах арга хэлбэрээр сонгон хамтран ажиллах гэрээ байгуулж ирсэн байна.

- Урьд нь хөтөлбөр хэрэгжүүлж байсан иргэн ААН
- Иргэн, ААНБ-ын тусгайлан бэлтгэсэн бүтээгдэхүүнд амталгаа хийх

2.1.9 Аймгаас алслагдсан сумдад эрүүл ахуйн шаардлага хангасан байр, зориулалтын тоног төхөөрөмжгүй зэргээс шалтгаалан хүнс, хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-ийг сонгон шалгаруулахаар зар урилгыг түгээдэг ч тухайн сум орон нутагт дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж ховор байдаг байна.

2.1.10 Мандах, Замын-Үүд, Сайншанд сумдад хөтөлбөр эхэлсэн цагаас хойш үдийн цайны зарим нэр төрлийг нэг аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлж ирсэн байна. Бэлтгэн нийлүүлэгч олдохгүйгээс Сайхандулаан, Хөвсгөл, Даланжаргалан зэрэг сумд хувь хүнтэй гэрээ байгуулсан байна.

2.2 Хүүхдийн нас биед тохирсон амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүн нийлүүлэгдэж чадахгүй байна.

Аж ахуй нэгжүүдийн нийлүүлж буй бүтээгдэхүүн журмын шаардлагыг хангахгүй байна.

2.1.11 БСШУСС, ЭМС-ийн 2018 оны А/448, А/268 хамтарсан тушаалаар ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээгээр өдөрт нийлүүлэх бүтээгдэхүүний шимт бодисын 15% уураг, 25% тос, 60% нүүрс ус байхаар тогтоожээ.

2.1.12 Үдийн цайны хөтөлбөрт оролцож буй ААН-дийн ирүүлсэн МХГ болон Хилийн мэргэжлийн хяналтын газрын хими, хор судлалын лабораторийн сорилын дүнгээс үзэхэд бүтээгдэхүүний тослог, эрдэс бодис, хуурай бодис, илчлэгийн үзүүлэлтийг шинжлүүлсэн хэдий ч дээрх тушаалаар батлагдсан **уураг, нүүрс ус** зэрэг үзүүлэлтүүдийг хамруулаагүй байна.

2.1.13 Хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон бэлэн бүтээгдэхүүн, хоолны нэгдсэн жишиг цэс, технологийн карт, стандарт, аргачлал байхгүй байна. Үүнээс шалтгаалж үдийн цайнд өгч буй хоолны орц, найрлага, жин, нэг хүүхдэд ногдох илчлэг, эрдэс бодисын хэмжээ харилцан адилгүй байна.

¹Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”

²БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалаар батлагдсан журмын 5-р зүйл:

Гэрээт гүйцэтгэгчийг сонгоход баримтлах шалгуур:

5.1. Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх,

5.2. Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх,

5.3. Шаардлагын дагуу савлах, зөөж тээвэрлэх боломжтой байх,

5.4. Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэмийг баримтлах нөхцөлийг бүрдүүлсэн байх,

5.5. Бүтээгдэхүүнээ цайны цагаас 30 минутын өмнө сургууль дээр авчирсан байх,

5.6. Гэрээний хэрэгжилтээр санхүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх.

2.1.14 Иймд бэлэн бүтээгдэхүүн нийлүүлэгч болон хүнс үйлдвэрлэгч нарт хүүхдийн бие махбодын онцлог, зохистой хооллолт, хоолны онцлогт тохирсон жор бүхий бүтээгдэхүүн хийх талаар сургалт хийх, гарын авлагаар хангах шаардлагатай байна.

2.1.15 Үдийн цайны бэлтгэн нийлүүлэгчийг сонгохдоо хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн байх шалгуур тавих нь зүйтэй байна.

Бэлтгэн нийлүүлэгчид гэрээнд тусгасан үнийн дүнгээр бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.

2.1.16 Үдийн цайны бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгчид ТББ болон гэрээнд заасны дагуу махан болон цагаан хоол, гурилан бүтээгдэхүүний үнийг 400 төгрөгөөр, шингэн бүтээгдэхүүнийг 200 төгрөгөөр тооцон нийлүүлсэн байна.

2.1.17 Даланжаргалан сумын Олон овоо багийн сургуульд үдийн цай нийлүүлэгч батлагдсан цэсээс өөр бүтээгдэхүүн нийлүүлж байхад сургуулийн эрхлэгч, хяналтын зөвлөл хяналт тавьж ажиллаагүй байна.

Бүлэг 3.

Шинжилгээний дүгнэлтгүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байна.

3.1 Талууд журмын заалтыг мөрдөөгүйгээс бүтээгдэхүүний чанар, илчлэг норм нь шалгуурыг хангахгүй байна.

Сургуулиуд үдийн цайны цэсийг журмын дагуу боловсруулж, хянаагүйгээс хориглосон бүтээгдэхүүн нийлүүлэгдсэн байна.

3.1.1 БСШУС, ЭМС-ын 2006 оны 379/341 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмаар үдийн цайны цэсийг сургуулийн эмч боловсруулж захирал батлахаар заасан байтал Айраг сумын сургуулийн үдийн цайны цэсийг бэлтгэн нийлүүлэгч боловсруулан батлуулсан байна.

3.1.2 Зарим сургуулийн үдийн цайны 2018 оны 9.10 дугаар сарын цэс зохиосон байдлыг авч үзэхэд бүтээгдэхүүний тоо төрөл, тэдгээрийн цэсэд эзлэх хувь харилцан адилгүй байна. Сургуулиудын цэсэд орсон бүтээгдэхүүний нэр төрлийг хүснэгтээр харуулав.

Сургуулийн нэр	Махан хоол		Цагаан хоол		Сүү, сүүн бүтээгдэхүүн		Гурилан бүтээгдэхүүн		Шингэн уух зүйл		Хориглосон бүтээгдэхүүн	
	Тоо	Эзлэх %	Тоо	Эзлэх %	Тоо	Эзлэх %	Тоо	Эзлэх %	Тоо	Эзлэх %	Тоо	Эзлэх %
Замын-Үүд 1-р сургууль	5	20	8	32	3	12	5	20	4	16	0	0
Замын-Үүд 2-р сургууль	6	23.1	6	23.1	4	15.4	5	19.2	5	19.2	0	0
Замын-Үүд 3-р сургууль	5	15.6	7	21.9	4	12.5	6	18.8	7	21.9	3	9.4
Хөвсгөл сургууль	10	25	2	5	2	5	7	17.5	18	45	1	2.5

Сайхандулаан сургууль	12	33.3	4	11.1	4	11.1	8	22.2	7	19.4	1	2.8
Мандах сургууль	8	22.9	4	11.4	1	2.9	5	14.3	14	40.0	3	8.6
Айраг сургууль	9	22.0	5	12.2	4	9.8	8	19.5	15	36.6	0	0.0

Дээрх хүснэгтээс харахад үдийн цайнд өгч буй бүтээгдэхүүний 15-33 хувь махан хоол, 5-32 хувь нь цагаан хоол, 5-15 хувь нь сүүн сүүн бүтээгдэхүүн, 14-22 хувь нь гурилан бүтээгдэхүүн, 16-45 хувь нь шингэн зүйл, 2-9 хувь нь хориглосон бүтээгдэхүүн эзэлж байна.

3.1.3 Сургуулиудын боловсруулсан цэсэнд бүтээгдэхүүний илчлэг, грамм, үнэ тусгагдаагүй, олгох сар, өдөр гариг нь тодорхойгүй байгаа зөрчил нийтлэг байв.

3.1.4 БСШУС, ЭМС-ын 2006 оны 379/341 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Үдийн цайн цэс зохиоход хориглох бүтээгдэхүүний жагсаалтыг³ зөрчсөн дутагдал цөөнгүй байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын 3-р сургуулийн 2018 оны 9, 10 сарын цэсэд сор шүүс /үйлдвэрийн ундаа/, чокопай оруулж, нийлүүлсэн.
- Хөвсгөл сумын сургуулийн цэсэнд печень, соло /шоколадтай печень/ нийлүүлсэн,
- Мандах сумын сургуулийн цэсэнд печень оруулж нийлүүлсэн,
- Сайхандулаан сумын сургууль цэсэнд печень оруулж нийлүүлсэн.
- Даланжаргалан сумын төвийн сургуулийн цэсэнд печень оруулж нийлүүлсэн

3.1.5 Зарим сургуулиуд бэлтгэн нийлүүлэгчийн тендерт болон үнийн саналд ирүүлсэн нэр төрлөөс өөр бүтээгдэхүүнийг цэсэд оруулан баталж, нийлүүлсэн байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын 3-р сургуулийн 9 сарын цэсэнд тендерт санал болгосон нэр төрлөөс 4 төрлийн өөр бүтээгдэхүүн, 10 сарын цэсэнд 6 бүтээгдэхүүн оруулсан.
- Замын-Үүд сумын 1-р сургуулийн 9 сарын цэсэнд тендерт санал болгосон нэр төрлөөс 5 төрлийн өөр бүтээгдэхүүн оруулсан

Үдийн цайны цэсэд хориглосон бүтээгдэхүүн нийлүүлсэн, нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрлөөс өөр бүтээгдэхүүнийг цэсэнд оруулж баталсан зөрчлийг арилгуулахаар сумын Засаг дарга, сургуулийн захирал нарт хариуцуулан хугацаатай албан шаардлага хүргүүлэв

Бэлтгэн нийлүүлэгч нар журмын заалтыг мөрдөөгүйгээс бүтээгдэхүүний илчлэг норм нь шалгуурыг хангахгүй байна.

3.1.6 БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалаар үдийн цайгаар авбал зохих хүнсний бүтээгдэхүүн, үндсэн шимт бодис ба илчлэгийн хэмжээг насны бүлгээр тогтоожээ. Журмын хавсралтаар үдийн цай хөтөлбөрөөр авах илчлэгийн хэмжээг 340 ккал гэж заасан.

³БСШУ, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалын 4.7-д Печень, бялуу, шоколад, чихэр зэрэг чихэрлэг бүтээгдэхүүн, давсалсан самар, мөхөөлдөс, түргэн хоол, хийжүүлсэн ундаа оруулахгүй байх,

3.1.7 Мөн ЭМС-ын 2014 оны 113 тушаалаар ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхэд хоногт авбал зохих илчлэгийн 10-15 хувь буюу 296 ккал илчлэг, харин БСШУСС, ЭМС-ийн 2018 оны А/448, А/268 хамтарсан тушаалаар 15 хувь буюу 262 ккал илчлэгийг үдийн цай хөтөлбөрөөр авахаар тооцсон байна.

3.1.8 Дээрх тушаалуудад заасан илчлэгийн хэмжээг хүүхдийн өдрийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний төрөл хэмжээнээс хамааран өөр тооцсон байна. Урьд гарсан шийдвэрүүд хүчинтэй байгаагаас мөрдөж ажиллахад хүндрэл үүсэхээр байна.

3.1.9 Үдийн цай нийлүүлж буй зарим ААН-ийн бүтээгдэхүүнд хийсэн лабораторын шинжилгээний дүн болон БСШУЯ-наас 2014 онд боловсруулсан “ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ гарын авлага”-д тусгагдсан үзүүлэлтийг бэлтгэн нийлүүлэгчийн тооцсон илчлэгтэй харьцууллаа.

Гурилан бүтээгдэхүүнийг шингэн бүтээгдэхүүнтэй хамт нийлүүлэхэд болон хоолыг жимсний шүүс болон цайны хамт нийлүүлэхэд үдийн цайгаар авах шаардлагатай илчлэгийн хэмжээ нь 216-270 ккал буюу зохих хэмжээнд хүрсэн байв. Харин хоолыг уух шингэн зүйлгүйгээр өгөхөд илчлэгийн хэмжээ 102-134 ккал байх байтал бэлтгэн нийлүүлэгч илчлэгийн хэмжээг буруу тооцсон байна. Тухайлбал Замын-Үүд сумын 2 дугаар сургуулийн бэлтгэн нийлүүлэгч Идэр-Өлзий Дархан-Уул ХХК нь гурвалжин будаатай шөлний илчлэгийг 380 ккал гэж тооцсон байна.

Сургуулиудын 2018 оны 9.10 сард нийлүүлсэн бүтээгдэхүүний илчлэгийн хэмжээг хүснэгтээр харуулав.

Сургуулийн нэр	ААН-ийн нэр	Өдөрт нийлүүлэх хоол	БН-ийн тооцсон Илчлэг ккал	Байвал зохих илчлэг ккал /268-296/
Замын-Үүд сумын 1-р сургууль	Бор билэг ХХК	Гурвалжин будаатай шөл	144.8	102
Замын-Үүд сумын 2-р сургууль	Идэр өлзийн Дархан уул ХХК	Гурвалжин будаатай шөл	380	128
Замын-Үүд сумын 3-р сургууль	Даян сайхан ХХК	Будаатай шөл	120.8	102
Сайхан дулаан сумын сургууль	Г.Энхцэцэг	Гурвалжин будаатай шөл	Байхгүй	134
		Сүүтэй цай		

3.1.10 Замын Үүд сумын ЕБ-ын 1.2.3 дугаар сургууль, Сайхандулаан сумдын сургуулиудад нийлүүлсэн бүтээгдэхүүний илчлэгийн хэмжээ нь өдөрт авбал зохих хэмжээнд хүрэхгүй байв.

3.1.11 Иймд зохих илчлэгийг хангасан бүтээгдэхүүнийг сонгож цэсэд өөрчлөлт оруулж батлах хэрэгтэй байна.

3.2 Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсан, шинжилгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн үдийн цайнд олгож байна.

Ихэнх сургуулийн үдийн цай нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ лабораторийн шинжилгээнд хамруулаагүй байна.

3.1.12 Аудитад хамрагдсан ихэнх сургуулиудын үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуй нэгжүүд журмын⁴ заалтыг мөрдөж бүтээгдэхүүнээ лабораторын шинжилгээнд хамруулж дүгнэлт гаргуулаагүй байна. Тухайлбал:

3.1.13 Сайхандулаан, Мандах, Айраг, Даланжаргалан сумын сургуулиудад үдийн цай нийлүүлж буй иргэн, ААНБ-ууд бүтээгдэхүүнээ нянгийн болон хими судлалын лабораторийн шинжилгээнд хамруулж байгаагүй байна.

3.1.14 Аудитад хамрагдсан сургуулиудын үдийн цайнд нийлүүлэгдэж байгаа бүтээгдэхүүний шинжилгээнд хамрагдсан байдлыг хүснэгтээр харуулав.

№	Сургуулийн нэр	Төрөл	МХГ-ын дүгнэлт		
			Нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ	нян судлал	Хими хор судлал/Илчлэг
1	1-р сургууль	махан болон цагаан хоол	7	0	0
2	5-р сургууль	махан болон цагаан хоол	10	0	0
3	3-р сургууль	махан болон цагаан хоол	16	10	10
4	3-р сургууль	гурилан бүтээгдэхүүн	7	4	4
4	Айраг сургууль	бүх төрөл	29	0	0
5	Даланжаргалан сургууль	бүх төрөл	11	0	0
6	Даланжаргалан бага сургууль	Бүх төрөл	22	0	0
7	Мандах сургууль	бүх төрөл	14	0	0
8	Сайхандулаан сургууль	бүх төрөл	14	0	0
9	Замын-Үүд 1-р сургууль	бүх төрөл	20	1	2
10	Замын-Үүд 3-р сургууль	бүх төрөл	13	0	0
11	Хөвсгөл сургууль	бүх төрөл	16	0	0

3.1.15 Бүтээгдэхүүний дээж хадгалах хөргөгчгүй, хөргөгчгүйгээс хөлдөөгчид хадгалсан, дээжийн устгал, бүртгэлийн дэвтэр хөтөлдөггүй сургуулиуд цөөнгүй байна. Тухайлбал:

- Даланжаргалан сумын бага сургуулийн бэлтгэн нийлүүлэгч нь дээж хадгалах хөргөгчгүйгээс дээжийг хөлдөөгчид хадгалсан.
- Айраг сумын сургууль: Нийлүүлсэн хоолны дээжийг аваагүй, 6 хоногийн өмнө өгсөн бүтээгдэхүүнийг устгалд оруулаагүй, дээжийн устгал, бүртгэлийн дэвтэр бүрэн хөтлөгдөөгүй

Үдийн цайнд нийлүүлж буй бүтээгдэхүүнийг нян болон хими хор судлалын шинжилгээнд хамруулж, зохих үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлэхийг сумын Засаг дарга, сургуулийн захирал нарт хариуцуулан албан шаардлага бичив.

Үдийн цайны бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт нь стандартад нийцэхгүй байна.

3.1.16 Үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэгч ихэнх ААН-дэд зориулалтын тээврийн хэрэгсэл байхгүйгээс хувийн тээврийн хэрэгслийн тээш, замын машинаар болон явганаар бүтээгдэхүүнээ зөөвөрлөн хүргэдэг байна.

⁴ БСШУС, ЭМС-ын 2006 оны 379/341 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмын 3.4-д Үдийн цайнд олгох бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх,

3.1.17 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэхэд тавигдах ерөнхий шаардлага MNS-5343:2011 стандарт 5.2.21-д “Талх, гурилан бүтээгдэхүүний тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүү тэвш, бүхээгтэй, стандартын тусгай зориулалтаар тоноглогдсон байна” гэж заасан. Гэтэл гурилан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч нар нь автомашины суудал, багажид тээвэрлэн тарааж байгаа нь стандартад нийцэхгүй байна.



3.1.18 Сургуулийн гал тогоог ашиглаж үдийн цай нийлүүлж буй аж ахуй нэгжүүд бэлтгэсэн бүтээгдэхүүнээ тусгай саванд хийж, ангийн багш нараар тараалгадаг байна.

3.1.19 Мандах, Сайхандулаан, Даланжаргалан, Хөвсгөл сумдын үдийн цай нийлүүлэгчид сургуулийн дотуур байр болон хувийн цайны газарт бэлтгэж, зориулалтын саванд хийж явганаар зөөвөрлөн, нийлүүлдэг байна. Зарим бэлтгэн нийлүүлэгч нэг савнаас бүх ангиудад аягалж тарааж байсан ба энэ нь дараа дараачийн хүүхдэд хүйтэн хоол, цай өгөхөд хүрч байна.

3.1.20 Сумдын цайны газар, дотуур байранд үдийн цайны бүтээгдэхүүн бэлтгэдэг ААН-д аймгийн төвөөс бүтээгдэхүүнээ татдаг бөгөөд өрөө тасалгаа, хөлдөөгч, тавиур хомс байдгаас зориулалтын бус газар нөөцөлдөг байна.

Бүлэг 4.

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

4.1 Холбогдох журмын заалтыг мөрдөж ажиллаагүйгээс өдөр тутмын хяналт хангалтгүй байна.

Эмч өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж байгаа ч нийлүүлэгчийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт гаргаагүй байна.

4.1.1 БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалаар батлагдсан журмын⁵ заалтыг аудитад хамрагдсан ихэнх сургуулийн эмч, бага ангийн сургалт хариуцсан эрхлэгч нар хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

⁵ БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалаар батлагдсан журмын 6.3-д Үдийн цай зохион байгуулахтай холбогдуулан сургуулийн эмч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ: 6.3.2-д Талуудын гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт тавих, гэрээг дүгнэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах, 6.3.6-д Таргалалттай болон жин багадалттай хүүхдэд онцгойлон анхаарал тавих ажлыг өрхийн эмчтэй хамтран зохион байгуулах.

- Сайншанд сумын 1 дүгээр сургууль, Замын-Үүд сумын 1, 2, 3 дугаар сургууль, Хөвсгөл, Мандах, Айраг, Даланжаргалан сумдын сургууль: Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэж, захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулаагүй
- Сайншанд сумын 2, 3 дугаар сургууль, Мандах, Айраг сумдын сургууль, Замын-Үүд сумын 1, 2, 3 дугаар сургууль: Таргалалттай болон жин багадалттай хүүхдийн өндөр, жинг хэмждэг боловч хэрхэн зохих хэмжээнд байлгах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.
- Сайхандулаан, Хөвсгөл, Даланжаргалан сумдын сургууль эмчийн орон тоо байхгүйгээс таргалалттай болон жин багадалттай хүүхдийн өндөр жинг хэмжих, үнэлэх ажил хийгдээгүй байна.
- Бэлтгэн нийлүүлэгч хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж буй эсэхэд хяналт тавьж дүгнэлт өгөөгүй байна.

4.1.2 БСШУ-ны сайд, ЭМ-ын сайдын 2006 оны 379/341 тушаалаар батлагдсан журмын 6.3.1-д “Сургуулийн эмч талуудын гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт тавих, гэрээ дүгнэх, захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах” гэж заасан байдаг. Гэтэл сумын Засаг даргын баталсан, бэлтгэн нийлүүлэгч, сургуулийн захирал нарын хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд эмчийн хүлээх үүрэг, хариуцлагын заалт тусгагдаагүй байна. Журам болон гэрээний заалтууд уялдахгүй байгаагаас гэрээг дүгнэх, хянах ажил орхигдож байна.

4.1.3 Мөн сумдын Засаг дарга нар хамтран ажиллах гэрээг баталж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт орхигдоход хүрч байна. Цаашид гэрээг боловсронгуй болгон БСУГ-ын дарга гэрээг баталж, хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

4.1.4 Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулийн эмч өдөр тутмын хяналтуудыг хийж байгаа боловч зарим ажил үүргүүд хангалттай түвшинд хийгдэхгүй байна. Тухайлбал:

Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх журамд шаардлага хангахгүй бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд буцаахаар заасан байдаг. Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн эмч шаардлага хангаагүй бүтээгдэхүүн нийлүүлэгдсэн байхад хяналт тавьж буцаагаагүй байв. Тухайлбал:

Бэлтгэн нийлүүлэгч Алтанчуу ХХК-аас 2018 оны 10-р сарын 26-ны өдөр нийлүүлсэн хоолны /тефтель/ будаа нь хатсан, луувангийн салат иссэн, хоол нь хөрсөн зэрэг шалтгаанаар 2г ангийн 40 хүүхэд, 4а ангийн 10 гаруй хүүхэд буцаасан, зарим нь хоолыг идэж, зарим нь үлдээсэн байна.

Гэтэл сургуулийн удирдлага, эмч, хяналтын зөвлөлөөс тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Энэ нь БСШУС, ЭМС-ын 2006 оны 379/341 дугаар тушаалаар батлагдсан “*Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам*”-ын 6.2-д “Сургуулийн үдийн цай үйлчилгээнд тухайн сургуулийн эмч өдөр тутмын хяналт тавина”, 6.3-д Үдийн цай зохион байгуулахтай холбогдуулан сургуулийн эмч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ,

6.3.7-д Үдийн цай бэлтгэх болон үйлчилж буй ажиллагсад эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан эсэх, хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж буй эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил, дутагдлыг тухай бүр нь арилгуулж ажиллах.

6.3.3-д Шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүнийг буцаах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.



Алтанчуу ХХК-ийн тештель



Алтанчуу ХХК-ний ажлын байр

Журмыг мөрдөж ажиллаагүй эмчид хариуцлага тооцуулахаар сургуулийн захиралд хариуцуулан албан шаардлага бичив.

4.1.5 БСШУС, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр хамтарсан тушаалын хавсралтад 481-ээс доош хүүхэдтэй сургуульд эмч ажиллуулахгүй бөгөөд сум, дүүргийн эрүүл мэндийн төв, багийн эмнэлэг, өрхийн эмнэлгээс шаардлагатай урьдчилан сэргийлэх болон бусад тусламж үйлчилгээг авч, хэрэгжилтийг хамтран зохион байгуулна гэж заасан. Хөвсгөл, Сайхандулаан, Даланжаргалан сумдын сургууль эмчгүй байгаа бөгөөд орон нутагт байгаа эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран үйлчилгээ авах, хэрэгжилтийг зохион байгуулах ажил хийгдээгүй байна.

4.1.6 Журмын 6.3.5-д “Үдийн цайны өмнө анги танхимын ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж буй эсэхэд хяналт тавих” гэж заасан боловч угаалтуур хүрэлцээгүйгээс гар угаахад хугацаа их зарцуулдаг гэдгээр ихэнх сургууль нойтон сальфетик, санитол хэрэглэж гарын ариун цэврийг хангуулж байна.

4.1.7 Аяга, тавгийг гэрээс нь авчруулахаар зохион байгуулсан сургуулиудын үдийн цай олголтод ажиглалт хийхэд зарим хүүхдүүд аягаа мартаж, аяга, тавгаа цүнхэлж явдаг ч угаадаггүй, дутуу угаадаг, өдөр бүр аяга зөөх нь хүндрэлтэй харагдаж байлаа. Ялангуяа цэвэр усны нэгдсэн системд холбогдоогүй сумдын сургуулиудын цайны газарт аяга тавгаа 3 дамжлагаар угаадаг ч бага хэмжээний ус хэрэглэж байгаа нь тос бохирдол, ариутгалын бодисыг бүрэн цэвэрлэхгүйгээс шаардлага хангахгүй байна.

4.1.8 Үдийн цайнд хамрагдаж буй сурагчдын гарын болон анги танхим, аяга тавгийн ариун цэврийг эмчээс гадна жижүүр багш, ангийн багш, сурагчид, эцэг эх, хяналтын комиссын гишүүд, сургалтын менежерүүд хянаж тэмдэглэл хөтөлж ирсэн байна.

Хяналтын комиссын үйл ажиллагаа хангалтгүй байна.

4.1.9 Хяналтын зөвлөлийг журмаар сургуулийн бага ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга ахална гэж заасан байтал менежер, эмч, мэргэжилтэн ахалсан байсан бөгөөд зарим суманд хяналтын зөвлөл огт ажилладаггүй байна. Тухайлбал:

- Зам-Үүд сумын 1, 2, 3 дугаар сургууль, Сайншанд сумын 3, 5 дугаар сургууль, Мандах сумын сургуулиудад бага ангийн сургалтын менежер,
- Сайншанд сумын 1 дүгээр сургуульд их эмч,
- Сайхандулаан сумын сургуульд сумын НХБ-ын мэргэжилтэн ахлахаар томилогдсон.
- Даланжаргалан сумын сургуулийн хяналтын комисс томилогдсон боловч 2017-2018 оны хичээлийн жилд ажил зохион байгуулаагүй байна.

4.1.10 Хяналтын комисс дээж авч зориулалтын хөргүүрт хадгалж байгаа эсэхэд хяналт тавих ажил тогтмолжоогүй, сургуулийн бие засах газар, угаалгын өрөөний үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт тавих гэсэн журмын заалт огт хэрэгжихгүй байна.

4.1.11 Ихэнх сургуулийн ажил хариуцсан албан тушаалтан, хяналтын комисст ажиллаж байгаа гишүүд холбогдох дүрэм, журмын талаар мэдээлэл дутмаг байгаагаас хяналтын комиссын үйл ажиллагаа хангалтгүй байна.

4.1.12 Цаашид хяналтын комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж, үдийн цайны үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4.2 Орон нутагт мэргэжлийн байгууллагууд хяналтаа хамтран хэрэгжүүлсэн байна.

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдох байгууллагууд хяналт тавьж бэлтгэн нийлүүлэгчийн үйл ажиллагаа болон дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгчээ.

4.2.1 Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмын 6.1-д “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд аймаг нийслэлийн эрүүл мэнд болон боловсрол, соёлын газар, мэргэжлийн хяналтын байгууллага хамтарсан хяналт тавина” гэж заасны дагуу дараах хяналт шалгалтууд хийгдсэн байна.

4.2.2 Аймгийн ЗД-ын 2017 оны А/653 захирамжаар аймгийн ЗДТГ, МХГ, БСУГ, ОНӨГ, сургуулиудын эмч, эцэг эхийн зөвлөлийн төлөөллийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон үдийн цайны үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулсан байна. Шалгалтаар дараах зөрчил илрүүлэн дүгнэлт өгчээ.

- Сайншанд сумын 2-р сургуулийн бэлтгэн нийлүүлэгч Арбит ХХК, 5-р сургуулийн бэлтгэн нийлүүлэгч Алтан түүчээгийн говь ХХК-ийн үйл ажиллагаа хангалтгүй,
- Бэлтгэн нийлүүлэгчид Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм журмыг өдөр тутамдаа мөрдлөг болгож хэвшээгүй, үйл ажиллагаа жигдрээгүй, аж ахуйн нэгжийн дотоод хяналт байхгүй,
- Сайншанд сумын 2, 5 дугаар сургуулиудын дотоод хяналт сайн байсан ба аж ахуйн нэгж байгууллагуудад гарсан зөрчлийг арилгуулахаар амаар болон, бичгээр зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Гэвч ААНБ гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна гэж дүгнэсэн байна.
- Мөн бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа өмнөх гэрээний биелэлт, үр дүн, гарсан зөрчлүүдийг арилгасан эсэхийг харгалзаж үнэлэх гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

4.2.3 Сайншанд сумын ЗД-ын 2017 оны А/105 захирамж, 2018 оны 3-р сарын 5-ны өдрийн удирдамжаар ЭМГ, БСУГ, Сумын ЗДТГ хамтран 2017 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр "Аюулгүй хүнс" сарын аяны хүрээнд сургууль цэцэрлэгийн хүүхэд, оюутан сурагчдын дотуур байр, ажиллагсдын цайны газарт, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хяналт шалгалтыг зохион байгуулж дараах зөрчил илрүүлсэн байна.

- Алтан чуу ХХК-ны 1-р сургуульд нийлүүлсэн үзэмний шүүсний үзэм бага орцоор хийгдсэнээс амт муутай, хоолыг хугацаа хоцроож ирүүлсэн.
- Цагаан сүүний буян ХХК-ны цөцгий, Мандах баян говь ХХК-ны нарийн боов хаяг шошго байхгүй,
- Сургуулиудад нийлүүлэгдэж буй Цагаан сүүний буян ХХК-ны ааруул хахарч иссэн зэрэг зөрчил илэрчээ.

Шалгалтаар дараах зөвлөмжийг хүргүүлжээ.

- Үдийн цайны чанар, зохион байгуулалтад байнгын хяналт тавих,
- Технологийн картад орох орц, нормыг зохиоход тавигдах шаардлагыг баримтлах, амархан муудаж, чанараа алдах, амин дэм, илчлэг багатай орцыг багасгах, давс, сахарын хэрэглээг аль болох бууруулах


4.2.2. Судалгаагаар сурагчид бүтээгдэхүүний амт чанарт сэтгэл ханамжтай байгаа ч бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтэй байна.

4.2.4 Судалгаанд нийт 11 сургуулийн 351 сурагчид хамрагдсанаас 172 буюу 49% нь эрэгтэй 179 буюу 51 нь эмэгтэй байгаа бол 7-8 насны 61, 9-10 насны 282, 11 настай 8 сурагч хамрагджээ.

4.2.5 Үдийн цай уухын өмнө гараа хэрхэн цэвэрлэгдэг вэ гэсэн асуултанд 144 буюу 41% нь сальфетикаар, 103 буюу 29% нь гараа угаадаг, 93 буюу 26% нь сальфетикаар арчиж, санитолоор ариутгадаг гэсэн байна.

4.2.6 Анги танхимын ариун цэврийн талаарх асуултад 76% нь сайн, 23% нь дунд, 1% нь муу гэж хариулсан.

4.2.7 Үдийн цайгаар олгогдож байгаа бүтээгдэхүүний амт чанарын талаар асуухад сүү, сүүн бүтээгдэхүүнийг 306 сурагч амттай, гурил, гурилан бүтээгдэхүүнийг 305 сурагч амттай, шингэн уух зүйлсийг 303 сурагч амттай, мах, махан бүтээгдэхүүнийг 297 сурагч амттай гэж хариулжээ.



4.2.8 Үдийн цай олгож байгаад сэтгэл ханамжтай байна уу гэсэн асуултад 97% нь тийм, 3% нь үгүй гэж хариулсан байна.

4.2.9 Олгож байгаа бүтээгдэхүүний хэмжээг 49% нь дунд зэрэг, 3% нь бага, 48 хувь нь их гэж хариулсан.

4.2.10 Судалгаанаас үзэхэд сурагчид хоолны амт чанар, анги танхимын ариун цэвэр болон хөтөлбөрийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаа боловч олгогдож байгаа бүтээгдэхүүний хэмжээг нэмэх хүсэлтэй байгааг харуулж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг зарим сургуулиуд зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Үдийн цайнд нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамрагдсан эсэхийг харгалзаж тендерт шалгаруулаагүйгээс шинжилгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн нийлүүлж байна.

Ихэнх сумд үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэх хуулийн этгээдийг чөлөөт өрсөлдөөнгүйгээр хамтран ажиллах гэрээ байгуулж ирсэн байна.

Сургуулиуд үдийн цайны цэсийг журмын дагуу боловсруулж, хянаагүйгээс хориглосон бүтээгдэхүүн нийлүүлэгдсэн байна.

Бэлтгэн нийлүүлэгч бүтээгдэхүүний илчлэг нормын шалгуурыг хангасан, хүүхдийн нас биед тохирсон амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүнийг сургуулиудад нийлүүлж чадахгүй байна.

Үдийн цайны цэс боловсруулах аргачлал байхгүйгээс сургуулиудын зохиосон цэсэд бүтээгдэхүүний илчлэг, грамм, үнэ тусгагдаагүй, олгох сар, өдөр гариг нь тодорхойгүй байна.

Үдийн цай хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэх ажил хангалтгүй байна.

Хяналтын комиссын бүрэлдэхүүн Үдийн цай хөтөлбөрийн холбогдох журмыг судалж үйл ажиллагаагаа жигдрүүлэх, хяналтыг үр нөлөөтэй болгох шаардлагатай байна.

Аудитаар нийт 520.8 сая төгрөгийн зөрчил илэрүүлж, холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлж, үдийн цайнд нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүнийг нян болон хими хор судлалын шинжилгээнд хамруулж, зохих үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлэх, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицлыг зөв сонгосон байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулахыг сумын Засаг даргад хариуцуулж 10 албан шаардлага, Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн эмчид хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, нийт 11 албан шаардлага бичив.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн өмчийн газрын дарга У.Баярбилэг, Замын-Үүд сумын ЗАА-ны дарга С.Саруулсайхан танаа

- Үдийн цайны бэлтгэн нийлүүлэгчийг сонгох шалгуурт хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн байх гэсэн заалтыг оруулах.
- Үдийн цайнд нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамрагдсан эсэхийг харгалзаж тендерт шалгаруулах
- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд БСУГ-аас төлөөлөл оролцуулах
- Сумдын сургуулиудад бэлтгэн нийлүүлэгчийг сонгох мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

Аймгийн БСУГ-ын дарга Ч.Отгонбаяр танаа

- Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж буй хоол хүнсийг шинжилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ авах
- Үдийн цай хөтөлбөрийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих, гэрээний хэрэгжилтийг хангуулах
- Бэлтгэн нийлүүлэгч, суралцагч нарт хүүхдийн бие махбодын онцлогт тохирсон жор бүхий бүтээгдэхүүн, зохистой хооллолтын талаар сургалт хийх, гарын авлагаар хангах.

Сургуулиудын захиралд

- Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний хугацаа дууссан тухай бүр дүгнэх
- Үдийн цайнд лабораторийн шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүн нийлүүлж байгаад байнгын хяналт тавих
- Үдийн цайны цэсийг журмын дагуу боловсруулж батлах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

П.ЭНХБАЯР

ШИНЖЭЭЧ

У.БАТТУЯА

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЛҮНДЭГМАА

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/27

Дорноговь аймаг, Сайншанд сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.12, 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”, 2017 оны 188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалга, аймгийн Төрийн аудитын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.
4. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Боловсрол, соёл урлагын газар, Орон нутгийн өмчийн газар, Айраг, Даланжаргалан, Мандах, Замын-Үүд, Сайншанд, Сайхандулаан, Хөвсгөл сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

9825972

Дарга, тэргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/27 тоот тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Хариуцагч		Албан шаардлага	
		Албан тушаал	Овог нэр	Дугаар	Товч утга
1	Хөвсгөл	Засаг дарга	Н.Энхбаяр	01/62	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		сургуулийн захирал	З.Мөнгөнбагана		
2	Даланжаргалан	Засаг дарга	С.Уранцэцэг	02/63	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		сургуулийн захирал	Х.Ганболд		
3	Замын-Үүд	Засаг дарга	Н.Алдарбаяр	03/64	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		3-р сургуулийн захирал	Д.Ариунаа		
4	Замын-Үүд	Засаг дарга	Н.Алдарбаяр	04/65	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		1-р сургуулийн захирал	А.Сүрэнхүү		
5	Сайншанд	Засаг дарга	С.Одбаяр	05/66	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		5-р сургуулийн захирал	Б.Эрдэнэцэцэг		
6	Сайншанд	Засаг дарга	С.Одбаяр	06/67	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		3-р сургуулийн захирал	Н.Оюунбуд		
7	Сайншанд	Засаг дарга	С.Одбаяр	07/68	Үдийн цайны махан болон цагаан хоолыг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		1-р сургуулийн захирал	С.Зоригт-Эрдэнэ		
8	Сайншанд	1-р сургуулийн захирал	С.Зоригт-Эрдэнэ	08/69	Хариуцлага тооцуулах
9	Айраг	Засаг дарга	Л.Мөнхжаргал	09/70	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		сургуулийн захирал	О.Одончимэг		
10	Мандах	Засаг дарга	Н.Отгонбаяр	10/71	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		сургуулийн захирал	А.Энхмэнд		
11	Сайхандулаан	Засаг дарга	Б.Эрдэнэжаргал	11/72	Үдийн цайны бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицолд хяналт тавих ажлыг зохион байгуулах
		сургуулийн захирал	Б.Нямжав		

